

БАТЛАВ:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.МӨНХБАТ

ГОВИЙН БҮСИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОРЫН ТЕХНИК
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 04 сарын 30-ны өдөр

Дугаар: 10/2024

Дундговь аймаг

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Монгол улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050”,- Монгол улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”.- Монгол улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус дэвшүүлсэн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх.- Эдийн засаг, хөгжлийн сайдын багцын IV.2.4.1 “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээ батлагдсан.
2	Байршил	<ul style="list-style-type: none">- Дундговь аймгийн Адагцаг сумын нутаг дэвсгэрт.
3	Зориулалт, хүчин чадал	<p>Зориулалт:</p> <ul style="list-style-type: none">- Малын гаралтай органик бүтээгдэхүүнийг ашиглан жилийн дөрвөн улирал шим тэжээлтэй бүх төрлийн малын гаралтай бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, савлах, тусгах зориулалттай байна.- Техник эдийн засгийн үндэслэл боловсруулсан байна. <p>Хүчин чадал</p> <ul style="list-style-type: none">- Жишмэл нэгжийн хүчин чадлыг тодорхойлно.- Жилд түүхий эдийн нөөцөөс хамаарч малын гаралтай бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлыг тодорхойлно. <p>Бүтээгдэхүүний ангилал</p> <ul style="list-style-type: none">- Малын гаралтай органик бүтээгдэхүүнийг ашиглан жилийн дөрвөн улирал шим тэжээлтэй бүх төрлийн малын гаралтай бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, савлах, тусгах.
4	Үйлдвэрлэлийн технологи	<ul style="list-style-type: none">- Малын гаралтай органик бүтээгдэхүүнийг ашиглан шим тэжээлтэй бүх төрлийн малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх.- Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх.- Байгаль орчны экологийн тэнцвэрт байдлыг хадгалах.
5	Ажиллах горим	<ul style="list-style-type: none">- Жилийн дөрвөн улиралд тасралтгүй үйл ажиллагаатай байна.

6	Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> - Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр /мах, сүү, арьс шир гэх мэт/ - Орчин үеийн техник технологитой мал нядалгааны цех. - Худалдаа үйлчилгээний хэсэг. - Гал тогоо, ажилчдын байр болон бусад туслах үйлчилгээний барилга байгууламжийг цогцоор нь төлөвлөх. - Инженерийн дэд бүтцийн эх үүсвэр, хангамжийг хүчин чадалд нийцүүлэн төлөвлөх.
7	Барилгын үндсэн бүтэц, материал	<ul style="list-style-type: none"> - Төслөөр.
8	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Эх загвар зурагт үндэслэн инженерийн хангамжийн ачаагал тооцож, хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөл гаргуулна. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг төслийг холбогдох норм дүрмийн дагуу боловсруулна. - Цогцолборын барилга байгууламж, үйлдвэрлэлийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон байх. - Гадна ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, дулаан хангамжийн шугам сүлжээний зураг төслийг бие даасан байдлаар шийдвэрлэж холбогдох байгууллагуудтай зөвшилцөн батлуулах. Тухайн сонгосон технологийн шийдэл нь байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй байхаар төлөвлөх.
9	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	Авто зам төсөллөх БНБД-ийн дагуу үйлдвэрлэлийн цогцолборын хэмжээнд үйлчилгээний зориулалттай авто зам төлөвлөх.
10	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"> - Эх загвар зураг боловсруулж батлуулна. - Иж бүрэн ажлын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж зөвшилцөж, батлуулах. - 2024 оны II-IV улирал.
11	Зураг төслийн бүрдэлд тавигдах шаардлага	<p>Зураг төслийн бүрдэл дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Цогцолборын иж бүрэн ажлын зураг, төсөл. - ТЭЗҮ, - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө. - Галын аюулгүй байдал болон эрүүл ахуйн дүгнэлт, байгаль орчны дүгнэлт. - Инженер-геологийн судалгааны дүгнэлт. - Магадлалын ерөнхий дүгнэлт /хавсралт дүгнэлтүүд/
12	Зураг төслийн байгууллагад тавигдах үндсэн шаардлага	Зураг төсөл боловсруулах байгууллага нь тухайн салбарт мөрдөгддөг олон улсын стандарт, норм норматив, технологийн талаарх мэдлэг, туршлагатай байх, энэ чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах боломжтой зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байна.
13	Захиалагч байгууллага	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

14	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Захиалагч аймгийн засаг даргын Тамгын газартай зөвшилцөн төсөл, арга хэмжээний байршлыг тодорхойлон, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулна. - Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэсний үндсэн дээр ажлын зураг төслийг боловсруулах. - Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь эрчим хүч, усны нөөцийн хэмнэлттэй материал ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх. - Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, техникийн аюулгүй ажиллагаанд тавигдах олон улсын болон Монгол улсын холбогдох стандартын шаардлага, норм дүрмийг баримталсан байх. - Цогцолборын барилга байгууламж, техник, технологи нь тухайн цутгийн цаг уурын онцлогт тохирсон, жилийн дөрвөн улиралд ажиллах нөхцөлийг хангасан байх. <p>Барилга байгууламж:</p> <ul style="list-style-type: none"> - Газар хөдлөлтийн тэсвэршилийн тухайн байршилд хийгдсэн инженер-геологийн дүгнэлтийг үндэслэнэ. - Эрчим хүчний хэмнэлттэй ашиглалтын зардал бага байх техник технологи, шийдлийг тусгах. - Үйлдвэрийн барилга байгууламж болон бусад туслах барилгын аврах гарцыг нормын дагуу төлөвлөх ба саадгүй түргэн аврагдах гарцыг төлөвлөх. <p>Гадна талбай:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэлийн цогцолборын хэмжээнд үйлчилгээний зориулалттай авто зам, тээврийн хэрэгслийн зогсоол төлөвлөн тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх. - Борооны ус зайлуулах байгууламжийг үйлдвэрийн эдэлбэр газрын өндөржилттэй уялдуулан норм дүрмийн дагуу иж бүрэн төлөвлөх. - Ногоон байгууламжийг холбогдох БНБД-ийн дагуу төлөвлөн, зам талбайд гэрэлтүүлэг хийж гадна талбайн тохижилтыг норм дүрмийн дагуу төлөвлөх. <p>Инженерийн шугам сүлжээ:</p> <ul style="list-style-type: none"> - Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэсний үндсэн дээр ажлын зураг төслийг боловсруулах. - Нөөц цахилгааны эх үүсвэртэй байхаар төлөвлөх. - Барилгуудын агааржуулалтын системийг орчин үеийн шаардлагад нийцсэн дэвшилтэт технологийн шийдэл бүхий тоног төхөөрөмжтэй төлөвлөх. - Гадна, дотор орчны хангалтын камер төлөвлөх.
15	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Тус үйлдвэрлэлийн цогцолборийн барилга байгууламжууд нь орчин үеийн дэвшилтэт техник технологитой бөгөөд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын норм ба

		дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байдлаар төлөвлөнө.
16	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21-02-02/; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/;
17	Байгал орчны үнэлгээ	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэнэ.
18	Эдийн засгийн тооцоо, төсөв ТЭЗҮ	<ul style="list-style-type: none"> - Цогцолборын барилга байгууламжийн нэг маягийн зураг төсөл, тонсг төхөөрөмжийн угсралт, өртөг, нэгдсэн төсвийн тооцоо хийгдэнэ. - Үйлдвэрлэлийн техник эдийн засгийн үндэслэл, шаардлагатай түүхий эдийн нөөц, зах зээлийн судалгаа, хөрөнгө оруулалт нөхөх хугацаа, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа зэргийг тусгасан байх. - Эдийн засгийн хувьд ашигтай байх суурь нөхцөлийг тооцсон байх.
19	Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Ажлын зураг төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн ажиллах. - Үйлдвэрлэлийн барилга байгууламжийн норм, дүрмийг хангасан байх.

ХЯНАСАН:


АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



П.ДОРЖБАТ

Ө.ЧАГНААДОРЖ

Э.ЭНХМЭНД

Ж.УЯНГА